



Хураангуй

- Тариалангийн индексжүүлсэн даатгалыг Монгол орны онцлогт нийцсэн хэлбэрээр нэвтрүүлэх шийдлийг зөв тодорхойлохын тулд эхний ээлжинд жижиг төслийн хэлбэрээр турших;
- Даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах, дагалдах үйлчилгээ үзүүлэх талаар зохих туршлага, ур чадвар эзэмшсэний дараа нийт салбарын төвшинд нэвтрүүлэх;
- Мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг эн тэргүүнд хэрэгжүүлж, оролцогч талуудын харилцан итгэлцлийг бий болгох;
- Индексжүүлсэн даатгалыг зээл, санхүүгийн үйлчилгээ, төрийн худалдан авалтын үйл ажиллагаанд нягт уялдуулж, тариаланчдад бодит давуу тал бий болгох замаар даатгалд хамрагдах сонирхлыг нь нэмэгдүүлэх;
- Малын индексжүүлэн даатгалын зах зээлийг хөгжүүлсэн туршлага, ололт амжилтаас тариалангийн индексжүүлсэн даатгалын тогтолцоонд нэвтрүүлэх боломжийн талаар нарийвчилсан судалгаа гүйцэтгэх.

Газар тариалангийн индексжүүлсэн даатгал: Олон улсын туршлага, Монгол улсад нэвтрүүлэх боломж

Уур амьсгалын өөрчлөлт Монгол орны хөдөө аж ахуйн салбарт ихээхэн эрсдэл учруулж байна. Тус улсад ургамлын бүрхэвчгүй газрын хэмжээ 1992-2006 оны хооронд гурав дахин нэмэгдэж, бэлчээрийн биомасс 20-30%-иар буурсан бол (Япон улсын Байгаль орчны яам, 2014) хүнсний гол таримал болох зусах буудайн усалгаагүй тариалан сүүлийн жилүүдэд ганд өртөх давтамж нь нэмэгджээ. Хамгийн сүүлд 2015 ба 2017 онд гангийн улмаас нилээд хэмжээгээр ургац алдсан. Газар тариалангийн үйлдвэрлэлийн эрсдэл уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Тариаланчдын эрсдэл даах чадварыг бэхжүүлэх, газар тариалангийн салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нэг арга зам нь газар тариалангийн цаг агаарын эрсдэлийн даатгал юм. Тариалангийн даатгалыг нэвтрүүлснээр түүнчлэн барьцаа хөрөнгө багатай тариаланчдад зориулсан зээлийн батлан даалтын хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бүрдэнэ (Дэлхийн банк, 2017). Одоогийн байдлаар банк, санхүүгийн байгууллагууд дахь чанаргүй зээлийн ихээхэн хувийг хөдөө аж ахуйн салбарын зээл эзэлж байгаа нь зээлийн хэмжээг хязгаарлах, барьцаа хөрөнгийн шаардлагыг чангатгахад хүргэж байна (АХБ, 2018).

Тариалангийн даатгал нь ийнхүү олон талын ач холбогдолтой тул Монгол улсын онцлогт нийцсэн хэлбэрээр нэвтрүүлэх асуудалд бодлогын төвшинд анхаарал хандуулах нь зүйд нийцнэ. Үүний тулд тариалангийн даатгалын зах зээлийг амжилттай хөгжүүлсэн улс орнуудаас суралцах, ялангуяа БНХАУ, Казахстан, Украин, Узбекистан зэрэг шилжилтийн эдийн засагтай орнуудад тариалангийн даатгал нэвтрүүлэх чиглэлээр ойрын жилүүдэд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдийн туршлагаас судлах нь зүйтэй.

Implemented by



International



Дээрх орнуудад хэрэгжсэн төслүүд тариалангийн даатгалыг тодорхой бүс нутагт түршсаны дараа нийт орон даяар нэвтрүүлсэн эсэх, тариаланчдын эрсдэл даах чадварыг бодитоор сайжруулж чадсан эсэх, өөрөөр хэлбэл урт хугацааны тогтвортой үр дүнд хүрч чадсан эсэхийг харьцуулж үзэхэд амжилттай хэрэгжсэн төслүүдэд ажиглагдаж буй нийтлэг тал нь тариалангийн даатгалыг хувийн хэвшил, эрдэм шинжилгээний ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилсан хэлбэрээр бий болгосон байна. Өөрөөр хэлбэл түршигдсэн тариалангийн даатгалын бүтээгдэхүүн амжилтанд хүрэх эсэх нь төслийн хүрээнд хийгдсэн гарааны хөрөнгө оруулалт, эрсдэлийн үнэлгээнд ашигласан индекс, эсвэл даатгалын байгууллагын төрлөөс хамаарах нь бага. Амжилтанд нөлөөлөх хамгийн гол хүчин зүйл нь оролцогч талуудын идэвхтэй, тогтвортой хамтын ажиллагаа юм. Түүнчлэн амжилттай хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүд тариалангийн даатгалын зах зээлийн оролцогчдын эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг тууштай баримталж, даатгалын бүтээгдэхүүнийг тариаланчдын бодит эрэлт хэрэгцээнд нийцүүлж чадсан байна. Тариалангийн даатгалын эрэлт хэрэгцээг тодорхойлох ажлыг тодорхой бүс нутгийг хамарсан туршилтын жижиг төсөл буюу судалгааны хэлбэрээр гүйцэтгэжээ.

Тариалангийн даатгалыг шинээр нэвтрүүлэхэд түүнчлэн төрөөс дэмжлэг үзүүлэх нь үр дүнтэй. Төсөл хэрэгжсэн ихэнхи орнуудад даатгалын хураамжийн зохих хувийг төр төлсөн нь тариаланчдын даатгалд хамрагдах боломж, сонирхлыг нэмэгдүүлсэн чухал дэмжлэг болсон нь гарцаагүй. Гэхдээ үүнээс дутахааргүй ач холбогдолтой дэмжлэг бол даатгалын байгууллага, банк, тариаланчид болон тариалангийн даатгалын зах зээлийн бусад оролцогч талуудын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг идэвхжүүлэх ажил юм.

Зөвлөмж

Хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай улс орнуудын түршлагад үндэслэн Монгол улсад тариалангийн даатгалын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр дараахь зөвлөмжүүдийг боловсруулав. Зөвлөмжүүд ерөнхийдөө тариалангийн даатгалын зах зээлийг хөгжүүлэх асуудлыг газар тариалангийн салбарт төрөөс баримтлах бодлогод тусгах, оролцогч талуудын ашиг сонирхол, үүрэг хариуцлагыг зохицуулах, тариаланчид болон даатгалын байгууллагуудад урамшуулал бий болгоход чиглэнэ.

- ❖ Тариалангийн индексжүүлсэн даатгалыг эхний ээлжинд жижиг төсөл хэрэгжүүлж, турших, улмаар төсөл хэрэгжүүлэх явцдаа даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах, дагалдах үйлчилгээ үзүүлэх талаар зохих түршлага, үр чадвар эзэмшсэний дараа нийт салбарын төвшинд нэвтрүүлэх нь зүйтэй. Ийнхүү шат дараалалтай нэвтрүүлэх нь даатгалыг тариаланчдын эрэлт, хэрэгцээнд бодитоор нийцүүлэхэд дөхөмтэй бөгөөд тариаланчдад буруу ойлголт, бодит бус хүлээлт, улмаар үл итгэлцэл үүсэх зэрэг эрсдэлээс сэргийлэх боломж олгоно.
- ❖ Экстейншний үйлчилгээ, мэдээллийн үйл ажиллагаанд хамгийн их анхаарал хандуулах шаардлагатай. Тариаланчид, даатгалын ба банк, санхүүгийн байгууллагууд, ХАА-н тоног төхөөрөмж борлуулагчид болон бусад түүхий эд ханган нийүүлэгчид, цаг уурын агентлаг, экстейншний үйлчилгээний байгууллага, нэгжүүдийг оролцуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлгүүдийг тодорхой давтамжтайгаар тогтмол зохион байгуулах нь маш чухал бөгөөд уг ажлыг төр өөрөө хариуцаж хэрэгжүүлэх нь зүйтэй. Мэдээллийн үйл ажиллагаанууд нь тариалангийн даатгалын талаар оролцогч талуудад жигд ойлголт бий болгож, хамтын ажиллагааг нь идэвхжүүлээд зогсохгүй даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт хүртээмжийг нэмэгдүүлдэг. Үүнийг зөвхөн даатгалын байгууллагуудын хариуцах ажил мэтээр ойлгох нь учир дутагдалтай.



- ❖ Тариалангийн индексжүүлсэн даатгалыг бие даасан тусгай бүтэц биш, ХАА-н санхүүгийн тогтолцооны нэг бүрдэл хэсэг гэж ойлгож, зээл, санхүүгийн үйлчилгээ болон төрийн худалдан авах үйл ажиллагаатай нягт уялдсан байдлаар нэвтрүүлэх нь зүйтэй. Түүнчлэн тариалангийн даатгалыг албан журмаар нэвтрүүлэх бус, харин даатгалд хамрагдсанаар зээлийн хүртээмж нэмэгдэх, зээлийн хүү багасах, газар тариалангийн орц, материал, тоног төхөөрөмжийн үнэ буурах, худалдан авах таатай нөхцөл үүсэх зэрэг давуу талуудыг бий болгох замаар тариаланчдын даатгалд сайн дураар хамрагдах эрмэлзлийг бий болгох нь урт хугацаанд тогтвортой үр дүнд хүрэх гол арга зам юм.
- ❖ Тариалангийн даатгалын тогтолцоо, бүтээгдэхүүнд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг төсвийн хэлбэлзлээс үл хамаарах байдлаар төлөвлөх хэрэгтэй. Төрийн дэмжлэг гэнэт зогсоход даатгалын тогтолцоо нуран унах эрсдэлтэй байдлаар зохион байгуулж хэрхэвч болохгүй.
- ❖ Тариалангийн индексжүүлсэн даатгал нэвтрүүлэхэд малын индексжүүлсэн даатгал нэвтрүүлсэн түршлагаас ашиглах нь зүйтэй. Зарим тариаланчид МИД-ын талаар зохих ойлголттой тул тариалангийн индексжүүлсэн даатгалыг хүлээж авахдаа харьцангуй дөхөм. МИД-ын зах зээлийг хөгжүүлсэн түршлага, ололт амжилтаас тариалангийн индексжүүлсэн даатгалын тогтолцоонд нэвтрүүлэх боломжийн талаар нарийвчилсан судалгаа дутагдаж байна.

Ашигласан хэвлэл:

ADB (2018): Mongolia. Finance Sector Fact Sheet. Available online at <https://www.adb.org/sites/default/files/publication/450161/fact-sheet-mongolia-finance-sector.pdf>, checked on 9/29/2019.

Ministry of the Environment Japan (2014): Climate Change in Mongolia. Outputs from GCM. Available online at https://www.env.go.jp/earth/ondanka/pamph_gcm/gcm_mongolia_en.pdf, checked on 9/29/2019.

World Bank (2017): Agricultural Productivity and Marketing in Mongolia. Available online at <http://documents.worldbank.org/curated/en/277781468195567857/pdf/101087-WP-P130366-PUBLIC-Box393257B-Agricultural-Productivity-and-Marketing-in-Mongolia-Feb-18-FINAL-with-pictures.pdf>, checked on 9/25/2019.



Зохиогчид:

Др. Лена Кунн, эрдэм шинжилгээний ажилтан

Др. Ихтёр Бобоёнов, эрдэм шинжилгээний ажилтан

ХБНГУ-ын Лайбницийн нэрэмжит Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэн (IAMO), Хөдөө аж ахуйн зах зээл, маркетинг ба олон улсын хөдөө аж ахуйн худалдааны сектор

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийг санхүүжүүлэгч Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.